

БАТЛАВ.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖИЙН ТӨВИЙН  
ЗАХИРАЛ  Б.НАРАНТУЯА

ХҮН АМЫН НАС БАРАЛТЫН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН  
ЧАНАРЫГ ҮНЭЛЭХ АЖЛЫН УДИРДАМЖ

ҮНДЭСЛЭЛ:

Эрүүл мэндийн хөгжлийн төв нь улсын хэмжээнд эрүүл мэндийн статистик мэдээллийг нэгтгэн, дүн шинжилгээ хийж, эргэн мэдээлэх үйл ажиллагааг хариуцдаг төдийгүй Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас эрүүл мэндийн мэдээллийн чиглэлээр гарч буй заавар, зөвлөмж, аргачлалыг нэвтрүүлэхэд санаачлага гарган дээд шатны байгууллагад санал оруулж шийдвэрлүүлэх, мэдээ, тайлангийн чанарт хяналт хийх, мэргэжил арга зүйгээр хангах үндсэн чиг үүргүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хүн ам зүйн хамгийн гол мэдээлэл нь хүн амын төрөлт, нас баралтын мэдээлэл бөгөөд эрүүл мэндийн мэдээллийн гол цөм нь болдог. Төрөлт, нас баралт болон нас баралтын шалтгааныг тодруулахад гол анхаарлаа бүхэлд нь хандуулах нь нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрөө юунд чиглүүлэх, эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтийг хэмжих, үнэлэлт дүгнэлт өгөхөд маш чухал.

Монгол Улсад сүүлийн 10 жилийн дунджаар 16.8 мянган нас баралтын тохиолдол бүртгэгдсэн ба шалтгаанаар авч үзвэл зурх судасны тогтолцооны өвчин (33.6%), хавдар (24.3%), осол гэмтэл, гадны шалтгаант нас баралт (16.6%) зонхилж байна.

Хүн амын нас баралт 2021 онд 19.9 мянга болж, сүүлийн 10 жилийн дунджаас 3094 хүн (18.4%)-ээр, өмнөх оноос 4009 (25.2%) хүнээр тус тус нэмэгдсэн. 10 000 хүн амд ногдох нас баралтын түвшин 2021 онд 61.8 байгаа бөгөөд цар тахлын нөхцөл байдлын үед хүн амын нас баралтын тохиолдол харьцангуй нэмэгдэж байгаа ба нас баралтын шалтгааныг үнэн зөв бүртгэх, кодлох, түүнд байнгын хяналт тавих асуудал нэн тэргүүнд тавигдаж байгаа болно.

Бүртгэл, мэдээллийн тогтолцоог сайжруулж, боловсронгуй болгоход хийгдэх үйл ажиллагааны эхний алхам нь өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, сайжруулах шаардлагатай зүйлээ болон нэн тэргүүнд хийх гол үйл ажиллагаагаа тодорхойлоход оршдог.

Иймд эрүүл мэндийн салбарт бүртгэгдэж буй Монгол улсын хүн амын нас баралтын мэдээллийн өнөөгийн байдалд үнэлгээ хийж, мэдээллийн чанарын дүн шинжилгээгээр тулгамдаж буй асуудлыг тодорхойлох замаар мэдээллийн үнэн бодит байдлыг хангаж, чанарыг сайжруулах шаардлага тулгарч байна.

ЗОРИЛГО:

Монгол улсын хүн амын нас баралтын бүртгэл мэдээллийн чанарыг ANACONDA tool-ээр үнэлж, тулгамдаж буй асуудлыг тодорхойлох замаар бүртгэл, мэдээллийн чанарыг сайжруулах

#### ХЭРЭГЖҮҮЛГЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА:

1. Хүн амын нас баралтын мэдээ, мэдээллийн чанарыг ANACONDA tool-ээр үнэлэх ажлын хэсгийг байгуулж, аргачлалыг танилцуулах сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах
2. Нас баралтын бүртгэл, мэдээллийн чанарыг шалгах ANACONDA tool-д оруулах үндсэн хүснэгт, data-г аймаг, нийслэл тус бүрээр боловсруулан бэлтгэх
3. Нас баралтын бүртгэл, мэдээллийн чанар, бүрэн гүйцэд байдлын үнэлгээ, тооцооллыг ANACONDA програмын дагуу аймаг, нийслэл тус бүрээр тооцоолон гаргах
4. Хүн амын нас баралтын мэдээ, мэдээлэлд хийсэн чанарын үнэлгээний тайлан боловсруулах.
5. Хүн амын нас баралтын мэдээ, мэдээлэлд хийсэн чанарын үнэлгээний тайланг хянах, англи хэл рүү орчуулах
6. Хүн амын нас баралтын мэдээ, мэдээллийн чанарын хяналтын үр дүнгээс анхаарах, сайжруулах зөвлөмжийг аймаг, нийслэл тус бүрээр боловсруулж, эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлэх
7. Үнэлгээний үр дүнг танилцуулах уулзалтыг Эрүүл мэндийн байгууллагын удирдлага, шийдвэр гаргагчид, мэдээ, мэдээлэл харууцсан мэргэжилтнүүдийг хамруулан зохион байгуулах
8. Үнэлгээний тайланг ДЭМБ-ын Монгол дахь төлөөлөгчийн газарт болон ЭМЯ-нд хүргүүлэх

#### ХЭРЭГЖИХ ХУГАЦАА:

2022 оны 04 сарын 10-наас 05 сарын 31

#### САНХҮҮЖИЛТ: ДЭМБ

14 910 000 төгрөг

#### ХАРИУЦАХ БАЙГУУЛЛАГА:

Эрүүл мэндийн хөгжлийн төв

#### ХҮЛЭЭГДЭЖ БҮЙ ҮР ДҮН:

1. Хүн амын нас баралтын мэдээ, мэдээллийн чанарыг ANACONDA tool-ээр үнэлэх ажлын хэсгийг байгуулж, аргачлалыг танилцуулах сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан байна.
2. Нас баралтын бүртгэл, мэдээллийн чанарыг шалгах ANACONDA tool-д оруулах үндсэн хүснэгт, data-г аймаг, нийслэл тус бүрээр боловсруулан бэлтгэсэн байна.
3. Нас баралтын бүртгэл, мэдээллийн чанар, бүрэн гүйцэд байдлын үнэлгээ, тооцооллыг ANACONDA програмын дагуу аймаг, нийслэл тус бүрээр тооцоолон гаргасан байна.
4. Хүн амын нас баралтын мэдээ, мэдээлэлд хийсэн чанарын үнэлгээний нэгдсэн тайланг боловсруулсан байна.
5. Хүн амын нас баралтын мэдээ, мэдээлэлд хийсэн чанарын үнэлгээний тайланг хянах, англи хэл рүү орчуулсан байна.
6. Хүн амын нас баралтын мэдээ, мэдээллийн чанарын хяналтын үр дүнгээс анхаарах, сайжруулах зөвлөмжийг аймаг, нийслэл тус бүрээр боловсруулж, эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн байна.
7. Эрүүл мэндийн байгууллагын удирдлага, шийдвэр гаргагчид, мэдээ, мэдээлэл харууцсан мэргэжилтнүүдэд чанарын үнэлгээний үр дүнг танилцуулах уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, шийдвэр гаргахдад тайлан, мэдээллийг хүргэсэн байна.


8. Үнэлгээний тайланг ДЭМБ-ын Монгол дахь төлөөлөгчийн газарт болон ЭМД-нд хүргүүлсэн байна.

Хянасан

Б.Доржпэлмаг /ЭММА – ны дарга/

Боловсруулсан

С.Даваажаргал /ЭММА-ны ахлах мэргэжилтэн/



**БАТЛАВ**  
**ЭРҮҮЛ МЭНДЭЙН ХӨРЖЛИЙН ТӨВИЙН**  
**ЗАХИРАЛ**   
**Б.НАРАНТУЯА**

**ХҮН АМЫН НАС БАРАЛТЫН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН**  
**ЧАНАРЫГ ҮНЭЛЭХ АЖЛЫН ТӨСӨВ**

№	Үйл ажиллагаа	Тоо/ширхэг	Нэгж үнэ (төг)	Төсөв (төг)	Хянасан
2	Нас баралтын бүртгэл, мэдээллийн чанарыг шалгах ANACONDA tool-д оруулах үндсэн хүснэгт, data-г аймаг, нийслэл тус бүрээр бэлтгэх	22 аймаг, нийслэл тус бүр 65 хуудас	22 аймаг, нийслэл тус бүр 41 хуудас*5000	4,510,000	
3	Нас баралтын бүртгэл, мэдээллийн чанарын үнэлгээг ANACONDA програмын дагуу шалгаж, аймаг, нийслэл тус бүрээр тооцоолж, дүн шинжилгээ хийх	22 аймаг, нийслэл тус бүр 6 хуудас	22 аймаг, нийслэл тус бүр 6 хуудас*30000	3,960,000	
4	Үнэлгээний нэгдсэн тайлан бичих, боловсруулах	50 Хуудас нь	50*30000	1,500,000	
5	Үнэлгээний тайлан хянах	50 Хуудас нь	50*20000	1,000,000	
7	Хүн амын нас баралтын мэдээ, мэдээллийн чанарыг сайжруулах зөвлөмж боловсруулах /аймаг, нийслэл тус бүр/	22 аймаг, нийслэл тус бүр 3 хуудас	22 аймаг, нийслэл тус бүр 3 хуудас*30000	1,980,000	
8	Үнэлгээний үр дүнг танилцуулах уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах	Уулзалтад оролцох хүний тоо-60 Өдрийн хоол Цайны зардал	өдрийн хоол 60 хүн*12000 Цайны зардал 60 хүн*9000	720,000 540,000	
9	Бусад зардал /бичиг хэрэг, хэвлэл, харилцаа холбоо/	Бичиг хэрэг	Хэлэлцүүлгийн туслах ажилтны ажлын хөлс	700,000	
<b>НИЙТ</b>				<b>14,910,000</b>	

Хянасан  
Хянасан  
Боловсруулсан

Б.Очир /Ахлах нягтлан бодогч/  
Б.Доржмялмар /ЭММА – ны дарга/  
С.Даваажаргал /ЭММА-ны ахлах мэргэжилтэн/

